



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

“Бат капитал менежмент” ХХК-д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.5, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2, Хорооны 2014 оны 08 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Бат капитал менежмент” ХХК-д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Бат капитал менежмент” ХХК /Л.Итгэлт/-д үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөл олгосонтой холбогдуулан компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг зохих шаардлагад нийцүүлэн хууль, журмын дагуу Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, хувийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Бат капитал менежмент” ХХК /Л.Итгэлт/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН